



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хурц тооцоолол аудит ХХК
Утас: 99980079 Цахим хаяг: lhama.dorj@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7-8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10-11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	15
3.6.1 Төсвийн төлөвлөлт	15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Акт	18
4.3 Зөвлөмж.....	18
4.3.1 Зардлын данстай холбоотой асуудал	18
4.3.2 Авлагын данстай холбоотой асуудал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ц.УРАНЧИМЭГ ТАНАА

2022.02.24 № 07/315
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 45/АД/50054
АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Тендерийн үнэлгээний хорооны 3 гишүүнд 850,500.00 төгрөгийн ажлын хөлс олгохдоо 97,800.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.2 "шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх", 32 дугаар зүйлийн 32.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5, 101, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийгмийн даатгалын шимтгэл 97,800.00 төгрөгийг харьяа дүүргийн Нийгмийн Даатгалын хэлтсийн холбогдох дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, нягтлан бодогч Б.Мядаг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Д.ЛХАМСҮРЭН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	391,000,46.76	781,364,584.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	36,223,138.59
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	33,361,536.59
31210	Төгрөг	0.00	33,361,536.59
31211	Төрийн сангийн харилцах	0.00	33,361,536.59
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	0.00	2,861,602.00
33	АВЛАГА	100,758,267.13	212,69,619.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	205,037,619.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	100,758,267.13	0.00
33500	Бусад авлага	0.00	7,932,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	7,932,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	290,242,279.63	532,171,826.98
35100	Түүхий эд материал	240,187,025.75	505,583,679.59
35130	Эм боох материал	240,187,025.75	505,583,679.59
35300	Бэлэн бүтээгдэхүүн	140,000.00	0.00
35400	Хангамжийн материал	49,915,253.88	26,588,147.39
35410	Бичиг хэргийн материал	3,443,250.00	2,259,700.00
35420	Аж ахуйн материал	12,640,109.51	10,722,672.50
35440	Түлш, шатах тослох материал	4,731,430.87	1,541,114.89
35470	Бусад хангамжийн материал	9,366,519.00	5,788,840.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,884,214,341.03	4,170,319,51.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,884,214,341.03	4,170,319,51.29
39200	Биет хөрөнгө	3,677,757,289.43	3,968,057,699.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,207,087,798.60	3,207,087,798.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(288,075,493.02)	(419,026,42.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	136,109,300.00	126,515,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(97,676,940.460)	(107,375,140.54)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,620,645,270.00	2,172,013,673.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,059,274,468.52)	(1,199,512,434.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	415,809,245.00	479,486,335.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(256,867,422.17)	(291,131,089.81)
39300	Биет бус хөрөнгө	206,457,051.60	202,262,051.60
39301	Програм хангамж	53,004,538.00	53,804,538.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(24,239,966.40)	(26,234,966.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	177,692,480.00	174,692,480.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,275,214,887.79	4,951,684,335.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	202,040,713.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	202,040,713.50
41300	Өглөг	0.00	202,040,713.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	202,040,713.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,275,214,887.79	4,49,643,622.36
51	Засгийн газрын хувь оролцоо	4,275,214,887.79	4,749,643,622.36
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,470,206,581.32	2,470,206,581.32
51200	Хуримтлагдсан үр дүн	(585,498,776.25)	(111,070,041.68)
51210	Өмнөх үеийн үр дүн	(858,678,606.35)	(585,498,776.25)
51220	Тайлант үеийн үр дүн	273,179,830.10	474,428,734.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,390,507,082.72	2,390,507,082.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,275,214,887.79	4,951,684,335.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,717,155,815.00	5,694,231,782.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,210,152,134.00	1,879,432,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,210,152,134.00	1,878,932,220.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,018,853,714.00	1,046,128,545.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	953,219,429.00	778,987,663.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,634,285.00	267,140,881.60
120009	Бусад орлого	0.00	10,973,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	150,378,299.00	582,714,203.48
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	40,920,121.00	239,116,471.37
122	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	0.00	500,000.00
122001	Хандив тусламж/дотоод/	0.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,507,003,681.00	3,814,799,562.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	630,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчдаас олгосон санхүүжилт	0.00	430,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд санхүүжилт	0.00	200,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,507,003,681.00	3,184,799,562.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,507,003,681.00	3,184,799,562.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,443,975,984.90	5,216,803,047.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,443,975,984.90	5,216,803,047.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,367,149,609.90	4,999,099,247.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,467,025,155.10	2,860,903,903.12
210101	Үндсэн цалин	2,467,025,155.10	2,860,903,903.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	334,566,953.40	405,327,325.85
210201	Тэтгэврийн даатгал	334,566,953.40	405,327,325.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,771,610.80	145,613,216.98
210301	Гэрэл, цахилгаан	58,517,072.00	67,322,811.66
210302	Түлш, халаалт	29,902,551.60	25,285,489.99
210303	Цэвэр, бохир ус	37,351,987.20	53,004,15.33
2104	Хангамж, бараа материалын зардал	99,877,496.94	121,29,263.01
210401	Бичиг хэрэг	24,968,429.90	24,460,359.00
210402	Тээвэр, шатахуун	2,384,920.00	5,700,635.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,888,171.55	12,732,945.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	49,509,222.99	66,393,854.80
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	14,126,752.50	12,541,468.00
2105	Нормативт зардал	747,40,143.69	974,674,826.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	538,733,735.79	778,847,466.05
210502	Хоол, хүнс	196,712,357.90	188,532,480.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,594,050.00	7,294,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	192550,975.00	8,435,108.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,086,060.00	24,346,224.00
210602	Тавилга	0.00	6,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	925,000.00	676,700.00
210604	Урсгал засвар	182,539,915.00	56,662,184.00
2107	Томилолт, зочны зардал	1,115,600.00	588,000.00
210702	Дотоод албан томилолт	1,115,600.00	588,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,366,543.00	65,006,828.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,122,383.00	46,226,129.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	228,096.00	190,080.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	413,976.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,500.00	1,004,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,684,700.00	1,004,500.00
210807	Газрын төлбөр	2,788,388.00	3,193,119.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,069,500.00	2,393,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	359,835,131.97	336,720,76.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,682,497.60	7,657,093.01

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,147,650.00	2,323,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	314,004,984.37	326,740,083.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,826,375.00	217,703,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,826,375.00	217,703,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,991,37.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,834,538.00	217,703,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	273,179,830.10	477,428,734.57
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	3,000,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	0.00	3,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	273,179,830.10	477,428,734.57

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.72	(868,178,606.35)	4,002,035,057.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	9,500,000.00	9,500,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,470,206,581.32	2,400,007,082.72	(858,678,606.35)	4,011,535,057.69
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт		(9,500,000.00)	0.00	(9,500,000.00)
Тайлант үеийн үр дүн			273,179,830.10	273,179,830.10
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,390,507,082.72	(585,498,776.25)	4,275,214,887.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,470,206,581.32	2,390,507,082.72	(585,498,776.25)	4,275,214,887.79
Тайлант үеийн үр дүн			474,428,734.57	474,428,734.57
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,470,206,581.32	2,390,507,082.72	(111,070,041.68)	4,749,643,622.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,529,643,477.00	4,768,121,755.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,022,639,796.00	1,158,359,812.28
120	Нийтлэг татварын бус орлого	1,022,639,796.00	1,158,359,812.28
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,022,639,796.00	1,147,386,812.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	953,101,829.00	780,195,299.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,537,967.00	266,433,245.60
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.00	100,758,267.13
120009	Бусад орлого	0.00	10,973,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,507,003,681.00	3,609,761,943.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,507,003,681.00	3,609,761,943.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,507,003,681.00	3,609,761,943.00
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,356,472,347.00	4,698,67,326.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,356,472,347.00	4,698,67,326.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,255,714,079.87	4,481,063,526.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,865,817,713.91
210101	Үндсэн цалин	0.00	1,637,466,151.32
210102	Нэмэгдэл	0.00	841,436,355.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	153,894,140.54
210104	Урамшуулал	0.00	233,021,067.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	386,452,244.25
210201	Тэтгэврийн даатгал	0.00	386,452,244.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	145,613,216.98
210301	Гэрэл, цахилгаан	0.00	67,322,811.66
210302	Түлш, халаалт	0.00	25,285,489.99
210303	Цэвэр, бохир ус	0.00	53,004,915.33
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	112,821,361.03
210401	Бичиг хэрэг	0.00	18,749,88.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	13,133,785.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	65,966,498.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	12,571,197.00
2105	Нормативт зардал	0.00	791,041,872.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	609,891,555.02
210502	Хоол хүнс	0.00	167,465,117.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	13,685,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	88,835,318.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	27,029,924.00
210602	Тавилга	0.00	6,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	771,700.00
210604	Урсгал засвар	0.00	54,283,694.00
2107	Томилот, зочны зардал	0.00	588,000.00
210702	Дотоод албан томилот	0.00	588,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	67,283,804.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	48,808,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	190,080.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,510,500.00
210807	Газрын төлбөр	0.00	1,314,594.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	3,460,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,255,714,079.87	22,609,996.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,255,714,079.87	19,926,396.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	2,683,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,758,267.13	217,703,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	217,703,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	217,703,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,758,267.13	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,758,267.13	0.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	173,171,130.00	69,354,428.59
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	173,171,130.00	33,131,290.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	173,171,130.00	33,131,290.00
2200	Дотоод эх үүсвэрээр	173,171,130.00	33,131,290.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	173,171,130.00	33,131,290.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(173,171,130.00)	(33,131,290.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	36,223,138.59
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	36,223,138.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон					/төгрөг/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,754,287,154.30	4,731,898,616.69	22,388,537.61	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,754,287,154.30	4,731,898,616.69	22,388,537.61	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,754,287,154.30	4,731,898,616.69	22,388,537.61	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,865,817,784.10	2,865,817,713.91	70.19	99.9
210101	Үндсэн цалин	1,636,514,156.35	1,637,466,151.32	951,994.97	100
210102	Нэмэгдэл	841,436,355.05	841,436,355.05	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,894,140.54	153,894,140.54	0.00	100
210104	Урамшуулал	233,973,132.16	233,021,067.00	(952,065.16)	99.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	386,452,244.25	386,452,244.25		100
210201	Тэтгэврийн даатгал	386,452,244.25	386,452,244.25		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,502,017,125.95	1,479,628,658.53	(22,388,467.42)	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,479,628,658.53	(1,479,628,658.53)	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,754,287,154.30	4,754,287,153.28	1.02	100
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,609,761,943.00	2,979,761,943.00	630,000,000.00	82.5
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		2,979,761,943.00	(2,979,761,943.00)	
1330	Төсвийн захирагчдаас		630,000,000.00	(630,000,000.00)	
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		430,000,000.00	(430,000,000.00)	
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		200,000,000.00	(200,000,000.00)	
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,043,766,944.17	1,144,525,210.28	(100,758,266.11)	109.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	790,674,469.17	890,932,735.68	(100,258,266.51)	112.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	253,092,475.00	253,592,474.60	(499,999.60)	100.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	100,758,267.13	0.00	100,758,267.13	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	33,361,536.59	(33,361,536.59)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.00	0.00	0.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	154.00	154.00	0.00	
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	97.00	97.00	0.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	47.00	47.00	0.00	
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00	0.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Цалин, шилэн дансны хэрэгжилт, авлага, өглөг, тайлант хугацаанд хийсэн худалдан авалтуудтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 14-ний хооронд Хурц тооцоолол аудит ХХК-ийн ахлах аудитор Э.Учралзаяа, аудитор Д.Гансүх, аудиторын туслах Б.Соёл нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын менежер Д.Наранчимэг хэрэгжүүлсэн.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/41а дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн даатгалаар арьс харшлын өвчин, эмчилгээний гоо заслын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг. Эрүүл мэндийн болон Сангийн сайдын тушаалаар төлбөртэй тусламж үйлчилгээний зохицуулалт хийх чиглэлийн хүрээнд Олон улсын түвшинд хүрсэн арьс, харшил, эмчилгээний гоо засал, арьсны мэс заслын тусламж үйлчилгээг үзүүлж, дараах зорилтуудыг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Лавлагаа шатлалын эмнэлгүүдийн хагас бие даасан байдал хэрэгжээд Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт орсон.
2. Эрүүл мэндийн тухай хуулийн 17.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр ТУЗ-аас томилсон байна.
3. Тус байгууллага төсвөө төлөвлөн, батлуулж, орон тоо бүтцэд өөрчлөлт оруулах, шагнал урамшуулал олгох, цалингийн санг батлуулах, гүйцэтгэлд суурилж цалинжуулах, Төрийн албаны цалингийн шатлал баримтлахгүй байх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх эрх мэдэл Төлөөлөн Удирдах Зөвлөлд шилжсэн.
4. Эрүүл Мэндийн Даатгалын сангаас өртөгт суурилан гүйцэтгэлээрээ санхүүжилтээ авдаг болсон.

5. Нийгмийн даатгалын тухай хууль
6. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
7. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Эрүүл мэндийн яамнаас 2021 онд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалт ороогүй байна. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,443,975.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 88,879.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 71,103.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 676,469.4 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	36,223.2	36,223.2
Авлага	100,758.3	212,969.6	112,211.3
Бараа материал	290,242.3	532,171.8	241,929.5
Үндсэн хөрөнгө	3,884,214.3	4,170,319.7	286,105.4
Нийт хөрөнгө	4,275,214.9	4,951,684.3	676,469.4
Өр төлбөр	0.00	202,040.6	202,040.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,470,206.6	2,470,206.6	0.00
Хуримтлагдсан үр дүн	(585,498.8)	(111,070.0)	(474,428.7)

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,390,507.1	2,390,507.1	0.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,275,214.9	4,951,684.3	676,469.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 36,223.1 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-наас 430,000.0 мянган төгрөг, Засгийн Газрын нөөц сангаас 200,000.0 мянган төгрөг, ЭМД-ын санхүүжилт 2,979,800.0 мянган төгрөг, Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,144.5 мянган төгрөгийн үлдэгдэл юм. 2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдлийг хагас бие дааж, гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой улсын төсөвт төвлөрүүлэхээ больсон.

Авлага дансны үлдэгдэл 212,969.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 205,037.6 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага, 7,932.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага тус тус байна. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 241,929.5 мянган төгрөгөөр өссөн нь /Ковид-19/ цар тахалтай холбоотойгоор 239,116.5 мянган төгрөгийн эм боох материал, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис, ковдын эсрэг вакцин, маск, нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, бээлий, халуун хэмжигч, комбинзон, халад, гар халдваргүйжүүлэх уусмал жавлин гэх мэт ЭМЯ-аас үнэ төлбөргүй хуваарилсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 286,105.4 мянган төгрөгөөр өссөн нь албан хэрэгцээнд 30,425.3 мянган төгрөг, ТӨБЗГ-ын А-1/1978 зөвшөөрлөөр балансаас балансад шилжин ирсэн уураар ариутгагч, багаж угаагч ултрасоник автомат машин, халдваргүйжүүлэн угаагч машин, гурван дамжлага бүхий гар угаагуур, таслагч, халуун уураар хатаагч, томруулагч шил, ус цэвэршүүлэгч, ширээ, цуглуулах, ширээ, савлалт хийх зориулалттай 255,680.1 мянган төгрөгийн хөрөнгүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 202,040,7 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбогдон эмийн өглөг үүссэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.1-д заасны дагуу “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, төлөвлөгөөтэй нийцүүлж, эмнэлгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг батлах” гэж заасны дагуу Эмнэлгийн Төлөөлөн Удирдах зөвлөл тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвөө батлуулж ажилласан байна. ТУЗ нь энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.11-ийн дагуу үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,754,287.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,754,287.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 4,754,287.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 4,731,898.6 мянган төгрөгийг зарцуулж, 22,388.5 мянган

төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй нь хагас бие дааж, гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/386 дугаар тушаалаар 5 сарын хугацаанд 40 ор дэлгэж ажиллуулснаар нийт 823,300.0 мянган төгрөгийн ковидын санхүүжилт, Ковидын дархлаажуулалт хийж 3,600.0 мянган төгрөг, тандалт шинжилгээний төлбөр 7,400.0 мянган төгрөг, нийт 834,300.0 мянган төгрөгийн Ковидтой холбоотой санхүүжилт авч үндсэн үйл ажиллагааны тасалдлыг нөхөж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Монгол Улсад /ковид-19/ цар тахал вирусын тархалт эрчимжсэнтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын А/496 тоот тушаалын дагуу 2021 оны 8 дугаар сард эмч эмнэлгийн ажилчдад 1,000.0 мянган төгрөг, нийт 140,000.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/585 тоот тушаалын дагуу 2021 оны 9 дүгээр сард эмч эмнэлгийн ажилчдад 400.0 мянган төгрөг, нийт 56,000.0 мянган төгрөг, нийт 196,000.0 мянган төгрөгийг нэг удаагийн мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгожээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь 2021 онд нийт 4,731,898.6 мянган төгрөгийн 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 238,996.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитын явцад бусад хууль тогтоомжийн хүрээнд анхаарч үзэхэд гарсан зөрчил ажиглагдсангүй.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 22,689.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 22,689.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Акт	2	670.3	2	670.3			100
2	Албан шаардлага	1	0	1	0			100
3	Зөвлөмж	2	11,747.7	2	11,747.7	-	-	100
	Нийт дүн	5	12,418.0	3	12,418.0	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- ✓ Дотоод эмийн сангаас эм, эмнэлгийн хэрэгсэл зарлагадахдаа E-Health программ руу тухайн эм, хэрэгсэл хүлээн авагч тасаг нь хүсэлт явуулсныг эмийн сан баталгаажуулдаг байна. Үүний дагуу сар, сараар нь нэгтгэл хийн санхүүгийн программ дээр зарлагын бичилт хийдэг байна. Дараагийн аудитаар дотоод эмийн сангийн E-Health программын бүртгэлийг авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,485.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,549.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 97.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 14,838.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 12,549.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ НБББББ-ийг Биет бус хөрөнгөөр бүртгэсэн 3,000.0 мянган төгрөг.
- ✓ Шилэн дансны 4 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан.
- ✓ Хувь хүнээр ажил гүйцэтгүүлэхдээ төлбөрийг суутган тооцсон боловч, татварт тайлагнаагүй 9,549.0 мянган төгрөг.

4.2 Акт

Аудитаар 97.8 мянган төгрөгийн зөрчилд 1 нөхөн төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Тендерийн хорооны үнэлгээний 3 гишүүнд 850.8 мянган төгрөг олгохдоо НДШ тооцоогүй 97.8 мянган төгрөгийн зөрчил нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 “Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна” 32.1.2 “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс” гэсэн заалттай нийцэхгүй, Эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: И-баримтгүй 6,906.3 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүртгэлд тавих хяналыг сайжруулах.

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Авлагын үлдэгдэл 7,932.0 мянган төгрөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах талаар зээлдэгч нартай тооцоо нийлж, авлага барагдуулах ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	НБББББ-ийг Биет бус хөрөнгөөр бүртгэсэн	Залруулсан	1	3,000.0	1	3,000.0				
2	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	Хувь хүнээр ажил гүйцэтгүүлэхдээ төлбөрийг суутган тооцсон боловч, татварт тайлагнаагүй.	Залруулсан	1	9,549.0	1	9,549.0				
3	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	И төлбөрийн баримтгүй худалдан авалтууд байна.	Зөвлөмж	1	6,906.3	-	-			1	6,906.3
4	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	Тендерийн хорооны үнэлгээний 3 гишүүнд 850.5 мянган төгрөг олгохдоо НДШ суутгаагүй,	Акт тогтоох	1	97.8			1	97.8		
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	7,932.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй	Зөвлөмж	1	7,932.0					1	7,932.0
Дүн					5	27,485.1	2	12,549.0	1	97.8	2	14,838.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Арьсны өвчин судлалын үндэсний төв	АХГ-2022/363/НА-СТА-ТШЗ	2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Зөвлөмж	1	-					1	
Нийцлийн аудитын дүн					1						1	
Нийт дүн					6	27,485.10	2	12,549.0	1	97.8	3	14,838.3

